



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

**ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХУГАЦААНДАА
ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙГАА НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “УЛСЫН ТӨСВИЙН 2024
ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ”**

2025 оны 04 дүгээр сар

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlansh@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	3 Error! Bookmark not defined.
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Зургийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
1.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ШААРДЛАГА ХАНГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	7
1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 88.5 хувь нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байна	7
1.2. Хөрөнгө оруулалтын ТАХ-г аргачлалын дагуу эрэмбэлэн, эдийн засгийн үр ашгийг тооцож төлөвлөсөн байна	9
1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан байна	9
1.4. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ийн 95.7 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн байна	10
2. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭХ ТАЛААР АНХААРАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	11
2.1. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна	11
2.2. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэх талаар анхаарах шаардлагатай байна	12
2.3 Тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулж ажилласан байна	13
3.1. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна	13
3.2. Барилга байгууламжийн ашиглалтад холбоотой зарим зөрчлүүдийг арилгах шаардлагатай байна	15
3.3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээг хүлээж авах боломжгүй байдал үүссэн байна	18
3.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаж ажиллаагүй байна	20
ДҮГНЭЛТ:	22
Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:	22
3. Худалдан авах ажиллагааны үр дүнд 495.4 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсон байна	Error! Bookmark not defined.
7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаж ажиллаагүй байна	Error! Bookmark not defined.
ЗӨВЛӨМЖ:	22
1. Улсын комиссын дүгнэлтээр хүлээн авч ашиглалтад орсон зарим байгууллагуудаас гарсан зөрчил дутагдлыг арилгуулж, ашиглагч байгууллагыг хэвийн ажиллуулах боломжоор хангаж ажиллах	22
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:	23

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТС	Зам, тээврийн сайд
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МАНУТХГ	Монгол Алтайн нурууны Улсын тусгай хамгаалалтын захиргаа
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
СПАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 2	ТЕЗ-ын 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний уялдаа	8
Хүснэгт 4	Төлөвлөсөн ТАХ-ний батлагдсан зураг төсөө	10
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байгууллагын мэдээлэл	11
Хүснэгт 6	Аймгийн ХААГ-аас зохион байгуулсан тендер шалгаруулалт	12
Хүснэгт 7	Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын судалгаа	14
Хүснэгт 8	Улсын төсвийн хөрөнгөөр 3 буюу түүнээс дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ	15

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сургуулийн спорт заалны барилга / Баяннуур сум, Ак арал баг/	17
Зураг 2	Сургуулийн спорт заалны барилга / Булган сум, 4 дүгээр баг/	18
Зураг 3	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум/	18

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх; • Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх; • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг дарга түүний харьяа аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	Монгол Улсын сайд, ЗГХЭГ даргын багцын 2 төсөл, арга хэмжээ (8 багцад задарсан)-нээс бусад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг салбарын сайдуудад шилжсэн тул хянах боломжгүй байна.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

журам"-ын дагуу зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, аудитор Ш.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 03 дугаар сарын 13-наас 04 дүгээр сарын 11-ний хооронд гүйцэтгэж, тайлагнах үе шатны ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 13-наас эхлүүлж, 04 дүгээр сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитын талбарын ажлыг санхүүгийн тайлангийн аудитын дараа богино хугацаанд төлөвлөж хэрэгжүүлсэн, хүний нөөц хязгаарлагдмал тул ачаалалтай ажилласан, хугацааны хувьд богино, зарим төсөл, арга хэмжээний захиалагчдаас нотлох баримт ирүүлэх үйл явц удаашралтай, олон жил үргэлжилсэн төсөл, арга хэмжээний баримт материал дутуу байх зэрэг хүндрэл, бэрхшээл байв.

1.УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ШААРДЛАГА ХАНГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 88.5 хувь нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байна

Монгол Улсын Их Хурлаас баталсан 2024 оны Төсвийн тухай хууль, Төсвийн тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Баян-Өлгий аймагт 13 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 89,854.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээний (44 багцад задарсан) 2024 онд санхүүжүүлэх дүнг 32,283.2 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №01. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө (сая төгрөг)

№	ангилал	Шинээр эхлэх ТАХ				Эзлэх хувь
		Тоо	багц	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
1	Барилга байгууламж	14	15	81,841.8	24,270.6	75.2
2	Их засвар	3	4	538.7	538.7	1.7
3	Тоног төхөөрөмж	9	25	7,473.9	7,473.9	23.2
Нийт		26	44	89,854.4	32,283.2	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль

Нийт санхүүжилтийн 75.2 хувийг барилга, байгууламж, 23.2 хувийг тоног төхөөрөмж, 1.7 хувийг их засварын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт №02. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ ТЕЗ-аар (сая төгрөг)

№	ТЕЗ	ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ЭЗЛЭХ ХУВЬ
1	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1	900.0	900.0	2.8
2	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗГХЭГ ДАРГА	2	1,403.7	1,403.7	4.3
3	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	1	247.2	247.2	0.8
4	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1	241.4	241.4	0.7
5	БОЛОВСРОЛЫН САЙД	5	6,553.3	4,353.3	13.5
8	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	6	69,731.0	16,788.4	52.0
9	СПАЖЗ САЙД	1	608.2	608.2	1.9
10	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	1	265.0	265.0	0.8
11	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	1	2,000.0	2,000.0	6.2
12	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	5	6,884.4	4,455.8	13.8
13	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	2	1,020.2	1,020.2	3.2
Дүн		26	89,854.4	32,283.2	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль

Зам тээврийн сайдын багцаас 6, Боловсролын сайдын багцаас 5, Эрчим хүчний сайдын багцаас 5, Эрүүл мэндийн сайдын багцаас 2, ЗГХЭГ-ын даргын багцаас 2, бусад 6 ТЕЗ-ийн багцаас тус бүр 1 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлах тухай” 194 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөг баталж, хавсралтаар 15 зорилтын хүрээнд 70 үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд уялдуулж төлөвлөсөн эсэхийг хянаж үзэхэд тухайн онд хэрэгжих 26 төсөл, арга хэмжээний 11.5 хувь нь буюу 3 төсөл, арга хэмжээ аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Хүснэгт №03. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний уялдаа (сая төгрөг)

№	ТЕЗ	2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ	Үүнээс:	
			Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд уялдуулж төлөвлөсөн ТАХ	Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй ТАХ
1	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1		1
2	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	1		1
3	БОУАӨСАЙД	1		1
4	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗГХЭГ ДАРГА	2	2	
5	БОЛОВСРОЛЫН САЙД	5	5	
6	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	6	6	
7	СПАЖЗ САЙД	1	1	
8	ХХААХҮСАЙД	1	1	
9	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	6	6	
10	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	2	2	
	НИЙТ	26	23	3

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дараахь ТАХ нь аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагдаагүй байна. Үүнд:

- Монгол Улсын Шадар сайдын багцын 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Онцгой байдал, Хот тохижуулах албаны тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 247.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хилийн цэргийн 0285 дугаар ангийн алба хаагчдын орон сууцны засвар (Баян-Өлгий аймаг, Цагааннуур тосгон);
- БОУАӨСайдын багцын 241.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй (2 багц) Хамгаалалтын захиргааны барилгын засвар /Монгол Алтайн нурууны УТХГ, Хөх сэрхийн нурууны УТХГ/

1.2. Хөрөнгө оруулалтын ТАХ-г аргачлалын дагуу эрэмбэлэн, эдийн засгийн үр ашгийг тооцож төлөвлөсөн байна

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5-т “хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх”, 29 дүгээр зүйлийн 29¹.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.1.1- т “тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх” гэж заажээ.

Дээрх хууль тогтоомжийг үндэслэн Сангийн сайдын 2018 оны “Журам болон аргачлал батлах тухай” 295 тоот тушаалаар хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г үнэлж эрэмблэх журам, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх, тооцох аргачлалыг баталсан байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 13 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 26 төсөл, арга хэмжээг (44 багцад задарсан) аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс хөрөнгө оруулалтын удирдлагын pimis.publicinvestment.gov.mn цахим системээр баталсан журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмблэн Сангийн яамд хуулийн хугацаанд хүргүүлж, хянуулсан байна.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан байна

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, 29¹.2.2² дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2³-д заасны дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний зураг төсвийг батлуулж, урсгал зардлын тооцооллыг хийж ажилласан байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас төлөвлөсөн Хилийн цэргийн 0285 дугаар ангийн алба хаагчдын орон сууцны засвар (Баян-Өлгий аймаг, Цагааннуур тосгон), Зам, тээврийн сайдын багцын 2, Эрчим хүчний сайдын багцын 2 төсөл, арга хэмжээний зурал төсөл байхгүй байна. (эрх шилжээгүй төсөл, арга хэмжээ бөгөөд гүйцэтгэгч нь орон нутгийн компани биш учраас аудитын явцад зураг төслийн талаар мэдээлэл байхгүй байна)

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

³ барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

Хүснэгт №04 Төлөвлөсөн ТАХ-ний батлагдсан зураг төсөө

№	ТЕЗ	ТАХ тоо	Батлагдсан зураг, төсөвтэй эсэх	Урсгал зардал тооцсон эсэх
1	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	1	1	1
2	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗГХЭГ	2	2	2
3	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	1		
4	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1	1	1
5	БОЛОВСРОЛЫН САЙД	5	5	5
8	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	6	4	4
9	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	1	1	1
10	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	1	1	1
11	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	1	1	1
12	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	5	3	3
13	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	2	2	2
		26	21	21

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.4. Төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ийн 95.7 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн байна

Монгол Улсын сайд, ЗГХЭГ даргын багцын 2 төсөл арга хэмжээ (8 багц), Боловсролын сайдын багцын 5 төсөл арга хэмжээ (12 багц), Эрчим хүчний сайдын багцын 5 төсөл арга хэмжээ (6 багц), Зам, тээврийн сайдын багцын 6 төсөл арга хэмжээ, СПАЖЗСайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцын тус бүр 1 төсөл арга хэмжээ, багцын 1 төсөл арга хэмжээ, ХХААХҮСайдын багцын 2 төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн байгууллагын өмчлөлд шилжих хөрөнгө оруулалт байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.14-д заасны дагуу аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 29,574.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 16,320.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 19 төсөл, арга хэмжээнд (36 багцад задарсан) тендер зарлаж, захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажилласан ба үр дүнд 459.4 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсон байна.

✓ Харин ЗТС-ын багцын 50.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 49.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Тал нуурын зам засвар /Баян-Өлгий, Толбо сум, 1 дүгээр баг/ ТАХ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, урсгал засварын ажлыг санхүүжүүлж хийж гүйцэтгэсэн нь

4 Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁵, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.2⁶, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2⁷, 13.4.3⁸ дахь заалтад нийцээгүй байна.

2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА

2.1. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 89,854.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 32,283.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 26 төсөл, арга хэмжээ (44 багц) батлагдсан.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 28,603.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 15,348.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 17 төсөл, арга хэмжээний (33 багц), аймгийн Онцгой байдлын газраас 900.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 900.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 1, Хөх сэрхийн нурууны УТХГ-аас 71.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 71.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны газраас боловсруулж төлөвлөсөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 17 төсөл арга хэмжээг 34 багцад хувааж тендер зарласан байна. Үүнээс 29 төсөл, арга хэмжээг нээлттэй, 1 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, 4 төсөл, арга хэмжээг ерөнхий гэрээний аргаар тендерийн журмыг баримтлан зохион байгуулсан байна.

Хүснэгт №05 Аймгийн ХААГ-аас зохион байгуулсан тендер шалгаруулалт

(сая төгрөг)

№	Тендер шалгаруулалтын арга	БӨ аймгийн ХААГазар	БӨ аймгийн ОБГазар	БӨ Хөх сэрхийн нурууны УТХГ	Тайлбар
1	Нээлттэй	29	1		Багцын тоогоор авсан
2	Харьцуулалт	1		1	
3	Нэг эх үүсвэрээр худалдан авах (ерөнхий гэрээ)	4			
	Нийт дүн	34	1	1	

Эх сурвалж: Аймгийн Худалдан авах ажиллагааны газар

⁵ Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

⁷ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

⁸ орон нутгийн авто замын засвар хийх

Аймгийн Засаг даргаар батлуулсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2⁹, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 2.2¹⁰ дахь заалттай нийцэхгүй байна.

Ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж болгов.

2.2. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэх талаар анхаарах шаардлагатай байна

Захиалагчийн зүгээс үнэлгээний хорооны бүрэлдэхүүн болон тендерийн зарыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1¹¹-д заасан хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹²-д заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д хуулийн дагуу ил тод зарласан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Онцгой байдлын газар болон Хөх сэрхийн нурууны УТХГ-аас худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн боловсруулан зохион байгуулж ажилласан боловч тендерийн баримт бичигтэй холбоотой хэд хэдэн зөрчил гарсныг оролцогч талууд тухай үед Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Сангийн яамд гомдол гаргаж тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийлгүүлсэн байна. Үүнд:

- ✓ Алтанцөгц сумын Хаш багийн цахилгаан хангамж” ТАХ-ний ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага”-ыг “ЖЕММН” ХХК хангасан боловч үнэлгээний хороо шаадлага хангаагүй гэж татгалзсан, “Дар-Али” ХХК нь нийгмийн даатгалын төлөлтийн мэдээллийг дутуу ирүүлсэн байхад ТШЗ 19.2-д заасан шаардлагыг хангасан гэж, мөн түрээсийн гэрээний дагуу ажиллуулахаар санал болгосон эксаватор, тулгуур ачигчийн мэдээллийг цахим системээр ирүүлээгүй байхад 19.2-д заасан шаардлагыг хангасан гэж үнэлсэн;
- ✓ “Боловсрол, хүүхэд хамгааллын салбарын тоног төхөөрөмж” ТАХ-ний Багц 6-д захиалагч нь Хүүхдийн цэцэрлэгийн иж бүрдэл худалдан авахад дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой тоног төхөөрөмжийг импортын бүтээгдэхүүний хамт багцалсан нь Төрийн болон орон нутгийн

⁹ Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна.

¹⁰ 2.5.Хуулийн 10.7-д заасан ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээ цахим дэлгүүрт бүртгэгдсэн бол ерөнхий гэрээний аргаар худалдан авахаар төлөвлөгөөнд тусгана.

¹¹ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

¹² Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹³, 8.2¹⁴, 10 дугаар зүйлийн 10.4¹⁵ дахь заалтуудад нийцээгүй;

- ✓ “Баяннуур сумын 100 ортой дотуур байрны барилга” ТАНХ-ний ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруултын баримт бичгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулаагүй гэсэн үндэслэлээр тендерт оролцогч компаниуд Сангийн яамд 2 удаа гомдол гаргаж тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийлгүүлсэн байна. Улмаар дээрх тендерийн маргаантай холбогдуулан тендерт оролцогч компаниуд захиргааны хэргийн анхан болон давж заалдах шүүхэд хандсан байна.

Тендерт оролцогч компани байхгүйн улмаас “Онцгой байдал, хот тохижуулах албаны тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерийг 4 удаа зарлаж “Бапкер” ХХК шалгарч тоног төхөөрөмж нийлүүлсэн, Хөх сэрхийн нурууны УТХГХЗ-ны барилгын засварын тендерийг 3 удаа зарлаж “Од дизайн” ХХК шалгарч засварын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Тендерийн маргаанаас үүдэлтэй Баяннуур сумын 100 ортой дотуур байрны барилгын ажил тухайн онд хэрэгжих боломжгүй болсон байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалттай холбоотой жил бүр давтан гарч буй зөрчлүүдийг багасгах үүднээс үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилогдох АЗ сертификаттай албан тушаалтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

2.3 Тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулж ажилласан байна

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 17 төсөл арга хэмжээнд (34 багц), Онцгой байдлын газар, Хөх сэрхийн нурууны УТХГ-аас тус бүр 1 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж, тендерийн баримт бичигт заасан шаардлага хангасан гүйцэтгэгч нарыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажилласан байна.

3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БҮРТГЭЛД БҮРЭН ТУСГАГДААГҮЙ БАЙНА

3.1. Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2 төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.

¹³ Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

¹⁴ Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална.

¹⁵ Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална.

Гэтэл орон нутгийн эрх бүхий албан тушаалтнуудын зөрчил, хариуцлагагүй байдлаас үүдэлтэй асуудал үүссэн тул Сангийн яамны 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/549 албан бичгээр ТЕЗ нарт "...улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийг хууль, журмын хүрээнд шийдвэрлэх хүртэл гүйцэтгэл хянан баталгаажуулах үйл ажиллагаанд орон нутгийн төлөөллийг оролцуулахгүй байх нь зүйтэй" гэсэн чиглэл хүргүүлэн түтгэлзүүлсэн байна.

Монгол Улсын сайд, ЗГХЭГ даргын багцын 134.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 132.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Алтай, Баяннуур, Бугат, Буянт, Дэлүүн, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур, Толбо сум/ төсөл, арга хэмжээ (2 багцад задарсан), 1,269.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,165.3 сая төгрөгийн санхүүжих дүнтэй Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ төсөл, арга хэмжээ (6 багцад задарсан)-ний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн бөгөөд санхүүжилтийг гүйцэтгэлтэй үндэслэн бүрэн олгосон байна.

Бусад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг салбарын сайдуудад шилжүүлсэн тул орон нутгийн аудитын байгууллагаас хянаж боломжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 8 ТЕЗ-ийн багцад 28,409.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн боловч дээрх маргаанаас болж түтгэлзүүлсэн байна.

Хүснэгт №06 Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын судалгаа (сая төгрөг)

№	ТЕЗ	ТАХ тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗГХЭГ	2	1,403.7	1,403.7
2	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	1	241.4	241.4
3	БОЛОВСРОЛЫН САЙД	5	6,553.3	4,353.3
4	ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	4	13,676.4	3,850.1
5	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	1	608.2	608.2
6	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	1	2,000.0	2,000.0
7	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	3	3,926.9	2,698.3
Нийт		17	28,409.9	15,155.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн боловч гэрээний хугацаанд дуусаагүй, хэрэгжилт нь удаашралтай дараа онд шилжих 3 буюу түүнээс дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөвт өртөг нь 22.4-227.4 хувиар нэмэгдсэн 12 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт №07 Улсын төсвийн хөрөнгөөр 3 буюу түүнээс дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ (сая төгрөг)

№	ТЕЗ	ТАХ-ний нэр	Хэрэгжих огноо	Үргэлжилж байгаа хугацаа / жилээр /	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Нэмэгдсэн өртөг	Нэмэгдсэн хувь
1	БОЛОВСРОЛЫН САЙД	Сургуулийн барилга, спорт заал, 940 суудал /Баян-Өлгий, Өлгий сум/	2021-2025	5	8,800.0	13,834.3	5,034.3	57.2
2	БОЛОВСРОЛЫН САЙД	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/	2021-2024	4	750.0	1,924.0	1,174.0	156.5
3	БОЛОВСРОЛЫН САЙД	Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/	2022-2024	3	2,300.0	2,402.8	102.8	4.5
4	БОЛОВСРОЛЫН САЙД	Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/	2022-2025	4	7,411.7	12,367.0	4,955.3	66.9
5	БОЛОВСРОЛЫН САЙД	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Улаанхус сум/	2022-2025	4	2,882.7	3,529.5	646.8	22.4
6	БОЛОВСРОЛЫН САЙД	Сургуулийн барилга, 640 суудал /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	2019-2025	7	5,000.0	10,597.7	5,597.7	112.0
7	БОЛОВСРОЛЫН САЙД	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	2020-2024	5	800.0	2,393.8	1,593.8	199.2
8	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЫН САЙД	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	2021-2025	5	1,930.0	6,803.9	4,873.9	252.5
9	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	Үерийн усны хамгаалалтын далан суваг /Баян-Өлгий, Өлгий сум/	2020-2025	6	13,200.0	23,896.7	10,696.7	81.0
10	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/	2022-2025	4	4,500.0	5,535.8	1,035.8	23.0
11	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2019-2024	6	8,752.9	28,656.2	19,903.3	227.4
12	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/	2019-2024	6	650.0	1,003.3	353.3	54.4
					56,977.3	112,945.0	55,967.7	98.2

Эх сурвалж. Аудитын судалгаа

Дээрх зөрчилтэй асуудал нь анхнаасаа төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулан батлуулсан, магадлалаар зураг төсөв нь нэмэгдсэн, ТАХ-ний санхүүжилтийг улсын төсөвт он дамжуулан хувааж төлөвлөснөөс ажил нь удааширч, төсөвт өртөг нь нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга, байгууламжийн хэрэгжилт удааширснаас төсөвт өртөг нэмэгдэх, тухайн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг буурах эрсдэл үүсээд байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга, байгууламжийг төлөвлөхдөө барилга, байгууламжийн ажил гүйцэтгэх хугацааг багасгах, тухайн оны санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах заалтыг холбогдох хуулиар зохицуулах шаардлагатай байна.

3.2. Хэрэгжиж дууссан зарим барилга байгууламжийн ашиглалттай холбоотой зөрчлүүдүүдийг арилгаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 57,017.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 25,958.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 төсөл, арга хэмжээг

(55 багцад задарсан) гүйцэтгэгч компаниуд төлөвлөсөн хугацаанд дуусгаж холбогдох эрх бүхий байгууллагуудаас гэрээг дүгнэж ажилласан байна.

Аудитын явцад багийн гишүүд 2024 онд хэрэгжиж дууссан ТАХ-ний хэрэгжилтийг шалгаж, талбар дээр ажиллахад дараах зөрчлүүд илэрсэн.

- “Өлке констракшн” ХХК хийж гүйцэтгэсэн Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ 18х12 хүчин чадал бүхий барилгыг ашиглалтад оруулах комисс 2023 оны 12-р сарын 28-ны өдөр ажиллаж, дутуу хийгдсэн ажлын талаар дараах үүрэг, даалгавар өгсөн боловч зарим нь биелэгдээгүй байна. Үүнд:
 - Авто зогсоолын гараажийн 122.16 м² талбайг 3 үе резин будгаар будах
 - Зоорийн давхарын бохирын өргөлтийн насос тавих (албан хаагч нар халуун ус, 00-ийн өрөөг ашиглах боломжгүй)
 - Сумны хошуу баригч байрлуулах (Галт зэвсэгийн сан бүрдүүлэх, шинжилгээ хийх боломжгүй байна)
 - Чулуун хөвөнг хатуу чулуун хавтангаар солих
 - Гадна талын ногоон байгууламжийн ажлыг гүйцээх
 - Цонхны тохируулга хийж өгөх (хурлын болон сургалтын өрөөний цонхны завсараас дулаан алдаж, шороо орох болсон)
 - Авто гараажийн яамнаас ус гардаг
- “Классиксолушн” ХХК хийж гүйцэтгэсэн Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 12 дугаар баг/
 - Комисс хүлээж авахдаа 13 ширхэг цонх хагарсан байсан, одоо хүртэл сольж өгөөгүй;
- “Еба констракшн” ХХК хийж гүйцэтгэсэн Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/
 - ТАХ-ний бохирын шугам өвөл хөлдсөн,
 - Ариун цэврийн өрөөний шалны плита доошоо хөндийрч унасан, ханын плита нь унах төлөвтэй байна
- “Викторибуйлдинг” ХХК хийж гүйцэтгэсэн Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Баяннуур сум, "Ак арал" баг/
 - Гүний худгийн болон бохирын шугам нь хөлдсөн
 - Хяналтын камер дутуу тавигдсан.
- “Нармаржан” ХХК хийж гүйцэтгэсэн сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, 1, 3, 5 дугаар баг, Ак арал баг/
 - Ариун цэврийн өрөөний плита наахдаа тэлэлт үүсээд, шалны плита хагарсан
 - Зарим өрөөнүүдийн гэрэл асахгүй, душийн өрөөнд гэрэл суурилуулаагүй
 - Сэндвич хавтангаас дулаан алддаг, хөөс дутуу шахсан
 - Душ өрөөний бохир ус гадагш урсахгүй байна
- “Нармаржан” ХХК хийж гүйцэтгэсэн сургуулийн дотуур байрны барилга, 30 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, 2 дугаар баг/
 - Гал тогооны заалны хананы эмульс ховхорсон
 - Өрөөнүүдийн цонхны эргэн тойронд мөөгөнцөр бий болсон
 - Зуухны нэг насос ажиллахгүй
 - 2-3 халаалтын радиатор цоорсон
- “Мурап” ХХК хийж гүйцэтгэсэн Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/

- Зарим албан хаагчдын конторын таазны булангаар бороо, цасны ус нэвтэрсний улмаас цонхны амалгааны хэсгийн замаск унаж, цуурсан, дулаан алдагдалтай байна.
- “Монсторй-Эра” ХХК хийж гүйцэтгэсэн Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум/
 - Усан сан хадгалдах өрөөний халаалтын шугам хөлдсөн, үүний улмаас цэвэр, бохир ус ашиглах боломжгүй болсон.

Зураг №01



Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Баяннуур сум, Ак арал баг

Зураг №02



Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/

Зураг №03



Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум/

Аудитаар дээрх зөрчлүүдийг Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3¹⁶, 14 дүгээр зүйлийн 14.3¹⁷-д заасны дагуу гүйцэтгэгч байгуулагуудаар арилгуулж, зориулалтын дагуу хэвийн ашиглах боломжоор хангаж ажиллахыг аймгийн аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

3.3. Хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээг хүлээж авах боломжгүй байдал үүссэн байна

- Боловсролын сайдын багцын 2,393.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/ ТАХ-а тухайн онд дуусгасан боловч аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас дараах зөрчлүүд илэрсэн тул байнгын ашиглалтад оруулахаас татгалзсан байна. Үүнд:
 - Зарим ашиглагдсан материалыг магадлан итгэмжлэгдсэн лабораторын шинжилгээнд хамруулаагүй, материалын стандарт нь тогтоогдоогүй нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3¹⁸, 40.1.11¹⁹, 40.1.12²⁰, 40.1.20²¹ дахь заалтуудыг;

¹⁶ "барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа" гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг

¹⁷ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна

¹⁸ Барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах ажилд олон улсын болон үндэсний стандартын шаардлага хангаагүй, гарал үүсэл, тохирлын гэрчилгээгүй материал, бүтээгдэхүүн, эдлэхүүн болон барилгын хэв хашимын тулаасанд мод хэрэглэхийг хориглоно.

¹⁹ барилга байгууламжид хэрэглэгдсэн материал, тоног төхөөрөмж, зураг төсөлд заасан техникийн үзүүлэлтийг хангаж байгааг нотлох, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан баталгаажуулах;

²⁰ барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах

²¹ гарал үүсэл, тохирлын гэрчилгээтэй барилгын материал хэрэглэх

- Анх тендер авахдаа барилгын бохирын шугам болон уурын зуухны зураггүй зөвхөн дан барилгыг барих зураг төсөлтэй тендер авсан боловч аймгийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, зураг төсөл нь батлагдаагүй /магадлалд ороогүй/ зураг төслөөр тус барилгад уурын зуух барьж, бохирын цооног барьж холбосон нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1²², 40.2²³ дахь заалтуудыг зөрчсөн.
- Эрүүл мэндийн сайдын багцын 1,003.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ортой /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/ ТАХ-г түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр (ямар ч зураг төсөвгүй) тендер зарлаж, гүйцэтгэгчээр 2019 онд “Улы дала” ХХК шалгарч 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 2024 онд ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ашиглалтад ороогүй, гүйцэтгэл нь 65 хувьтай зогссон байдалтай байна. Тендерт 2019 онд “Улы дала” ХХК шалгарсан. 2019 оны Төсвийн тухай хуулиар тухайн онд санхүүжих 250.0 сая төгрөг баталж гүйцэтгэлээр санхүүжилтийг авсан. 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн ЕД-1533/2020 дугаартай магадлалын дүгнэлтээр барилга, байгууламжийн төсөвт өртгийг 1,003.3 сая төгрөгөөр баталсан. 2020-2022 оны төсөвт мөнгө батлагдаагүй, 2023 онд 50.0 сая төгрөг тусгасан байна. 2024 онд Төсвийн тухай хуульд 2020 онд баталсан магадлалын үнийн дүнгийн үлдэгдэлээр баталсан нь үнийн өсөлттэй холбоотой барилгын угсралтын ажлыг хийж боломжгүй болсон. Захиалагчийн зүгээс зураг төсвийн болон гүйцэтгэгч компаниудтай хандаж хамтран хуралдсан. Захиалагч болох Эрүүл мэндийн ямаар уламжлуулан Барилгын хөгжлийн төвд хандаж албан тоот хүргүүлсэн байна. Гэвч Барилгын хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүдээс татгалзсан хариу өгсөн байна.
- Боловсролын сайдын багцын 1,924.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/ ТАХ-г түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр тендер зарлаж, гүйцэтгэгчээр 2021 онд “Лаулау” ХХК шалгарч барилга угсралтын ажлыг эхэлүүлсэн ба 2024 онд ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ашиглалтад ороогүй байна.
- Боловсролын сайдын багцын 2,402.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/ ТАХ тендер зарлаж, гүйцэтгэгчээр 2022 онд “Мурап” ХХК шалгарч барилга угсралтын ажлыг эхэлүүлсэн. 2024 онд ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан боловч одоо хүртэл ашиглалтад ороогүй байна.
- ЦХИХХСайдын багцын 585.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ ТАХ тендер зарлаж, гүйцэтгэгчээр 2021 онд “Файвер Оптик Констракшн” ХХК шалгарч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 2021 оны 11 дүгээр сарын 12, 2024 оны 10 дугаар сарын 15-нд гэрээний хугацааг 2 удаа сонгосон боловч одоо хүртэл ашиглалтад ороогүй байна.
- ССАЖЗСайдын багцын 1,799.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт цогцолборын барилга /Баян-Өлгий, Ногооннуур сум/ ТАХ нь 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлсөн боловч ашиглалтад ороогүй. 2019

²² барилгын ажлыг зөвшөөрөл, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэх, хяналт тавих;

²³ Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

онд тендер зарлаж “Мурап” ХХК шалгарсан. 2020 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд онц байдал (Коронавируст халдвар) зарласантай холбоотой хил хаагдсаны улмаас гол түүхий эд материалыг (ган бүтээц, хөөсөмсөр хавтан, арматур, цемент) татан авалт удааширсан ба барилгын материалын үнэ 2019 онд магадлалаар оруулсан төсөвт өртөгөөс 2-3 дахин нэмэгдсэнээс бэрхшээл үүссэн байна. Одоогийн байдлаар барилгаа угсралтын ажил 95 хувьтай байна.

Нөхцөл байдлыг Биеийн тамир, спортын улсын хорооны холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, захиалагч, хянагч, зохиогч, гүйцэтгэгч нарын хамтарсан хуралдаанаар барилгаа, байгууламжийг дахин магадлалд оруулахаар шийдвэрлэж, 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1808/2024 тоот магадлалын дүгнэлтээр 468.7 сая төгрөгөөр нэмж баталсан байна. 2024 оны хагас жилээс эхлэн яамдуудын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсоноор уг барилгаа, байгууламж ССАЖЗС-ын багцад шилжсэн байна. Захиалагч байгууллага болох ССАЖЗС-ад удаа дараа албан тоотгоор хандсан боловч хариу ирүүлээгүй байна. (ССАЖЗЯ-ны хөрөнгө оруулалтын газарт 2024.11.29-ний өдрийн №87, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газарт 2024.12.10-ний өдрийн №93, УАГ-ын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт 2024.11.29-ний өдрийн №86, УИХ-ын гишүүн Т.Аубакирт 2025.03.31-ний өдрийн №86, ССАЖЗС-ад 2025.03.31-ний өдрийн №06 албан тоотгоор хандсан байна)

Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 03/278 дугаар албан бичгээр хэрэгжилт нь удаашралтай хууль тогтоомж болон гэрээний заасан хугацаанд хүлээлгэж өгөөгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж баталгаажуулсны үндсэн дээр санхүүжүүлэх, гэрээг дүгнэж, эцсийн тооцоог 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор баталгаажуулан ажиллах талаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарт чиглэл өгсөн байна.

3.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2024 онд шинээр хэрэгжих болон он дамжсан нийт 57,017.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 37 төсөл, арга хэмжээг (55 багцад задарсан) хэрэгжиж дуусгасан ба ашиглагч байгууллагууд хөрөнгийн бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Аудитаар хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд данс бүртгэлд тусгаагүй дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын багцын 1,269.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ ТАХ-ний Багц 1, 2, 3-аар төсвийн байгууллагуудад нийлүүлүүлсэн 291.0 сая төгрөгийн үнэ бүхий 112 ширхэг мотоциклыг хууль хүчний болон улсын төсвийн зарим байгууллага эрх бүхий байгууллагаас шийдвэр гараагүй гэж орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ ХХААХҮС-ын багцын 2,263.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилгыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүсэлт явуулсан, шийдвэр гараагүй тул орлого аваагүй байна.

- ✓ Боловсролын сайдын багцын 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Боловсрол, хүүхэд хамгааллын салбарын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 276.9 сая төгрөгийн үнийн дүнтэй тоног төхөөрөмжийг аймгийн Хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын газарт хүлээлгэн өгөөгүй. ГБХНХС-ын багцаас нийлүүлэх ёстой тоног төхөөрөмжийг Боловсролын сайдын багцаас нийлүүлсэн тул асуудал үүссэн байна.
- ✓ Боловсролын сайдын багцын 750.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Баяннуур, Сагсай, Дэлүүн сум/ хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 4.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагууд орлого аваагүй.
- ✓ Боловсролын сайдын багцын 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Боловсрол, хүүхэд хамгаалалын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 38.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг холбогдох байгууллагууд орлого аваагүй байна.

Боловсролын сайдын багцын 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Боловсрол, хүүхэд хамгааллын салбарын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ хөрөнгө оруулалтаар Сагсай сумын 3 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн ухаалаг самбарыг зарлагын баримтаас 1.2 сая төгрөгөөр, Баяннуур сумын Цагаан арал багийн ерөнхий боловсролын сургуульд нийлүүлсэн сурагчийн ширээ сандлыг 1.9 сая төгрөгөөр дутуу, Алтай сумын 2-р цэцэрлэгт нийлүүлсэн 1-р хоолны тогоог 1.1 сая төгрөг, Өлгий сумын 2-р цэцэрлэг, Цэнгэл сумын 2-р цэцэрлэгт нийлүүлсэн шөлний индукцийг тус бүр 2.0 сая төгрөгөөр илүү орлого авсан байна.

Аудитын дүнгээр аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт данс бүртгэлд тусгаагүй тоног төхөөрөмжүүдийг орлого авхуулж, зөрчил арилгах албан шаардлага өгч, Хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын газарт нийлүүлэхээр төлөвлөсөн 276.9 сая төгрөгийн үнийн дүнтэй тоног төхөөрөмжийн асуудлыг холбогдох газруудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэхийг зөвлөмж болгов.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдсан байна.
2. Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулж ажилласан байна.
3. Улсын комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан зарим барилга байгууламжийн ашиглалттай холбоотой зөрчлүүдийг арилгаагүй байна.
4. Зарим төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй он дамжиж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.
5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 6 төсөл, арга хэмжээг хүлээж авах боломжгүй байна

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

I. Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:

1. Улсын комиссын дүгнэлтээр хүлээн авч ашиглалтад оруулсан зарим барилга байгууламжийн ашиглалттай холбоотой гарсан зөрчил дутагдлыг холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгч арилгуулж, хэвийн ашиглах боломжоор хангах;

II. Аймгийн Худалдан авах ажиллагааны газар/Т.Назым/-т:

1. Ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг төлөвлөгөөнд тусгаж ажиллах

III. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар /Б.Айдын /-д:

1. Аймгийн Хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын газарт нийлүүлэхээр төлөвлөсөн тоног төхөөрөмжийн асуудлыг холбогдох газруудад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

УТХО-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох журамд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлэхийг санал болгож байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга, байгууламжийг төлөвлөхдөө барилга, байгууламжийн санхүүжих хугацааг багасгах, тухайн оны санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаатай уялдуулах, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх хууль, эрх зүйн зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах заалтыг холбогдох хуулиар зохицуулах санал дэвшүүлэх;
- Гэрээний хугацааг удаа дараа сунгуулж, төсөвт өртгийг нэмэгдүүлдэг, захиалагчтай байгуулсан гэрээг зөрчдөг гүйцэтгэгчийн талаар мэдээллийн сан бүрдүүлэх, тендер шалгаруулалтад мэдээллийн санг нэг үзүүлэлт болгох талаар санал оруулах;



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/11

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1-ийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдвээр хийсэн нийцлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, аудитаар өгсөн албан шаардлагыг 2 дугаар тус тус хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Е.Зангар/, Боловсролын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Айдын/, аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга /Т.Назым/ -д даалгасугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (У.Ербол)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг аудитын менежер (Х.Женисбек)-т даалгасугай.



Ж.АЙГҮЛ



МОНГОЛ УЛС
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-2483, Факс: (976) 7042-3603
E-mail: info@bo.gov.mn
<http://www.bayan-olgi.gov.mn/>

2025. 04. 23 № 1-01/608
танай _____-ны № _____-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.АЙГУЛ ТАНАА

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн талаарх нийцлийн аудитын зөвлөмжтэй танилцлаа.

1. Улсын комиссын дүгнэлтээр хүлээн авсан зарим барилга байгууламж дээр гарч буй зөрчил дутагдлуудыг холбогдох компаниудаар арилгуулах талаар үүрэг даалгавар өгч, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

2. Зөрчил гаргасан нэр бүхий компаниуд, гаргасан зөрчлөө арилгаагүй тохиолдолд цаашид худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй байх талаар анхааруулах болно.

ЗАСАГ ДАРГА



Е.ЗАНГАР

8325050770



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

83129 Өлгий, 11-р баг, Эрүүл мэнд 1 дүгээр
гудамж, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн
3 давхар Баян-Өлгий аймаг
Утас: 75073434 Цахим шуудан: tender@bo.spa.gov.mn

2025.04.22 № 01/96
танай 2025.04.21 -ны № 429 -Т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ж.АЙГҮЛ ТАНАА**

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвээр
хийсэн нийцлийн аудитын тайланд саналгүй болно.

АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН



Х.ЖАНИБЕК

8332500197



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2367

Website: www.edu.bo.gov.mn, E-mail: bayanulqii.edu@gmail.com

2025.04.22 № 292
танай 2025.04.21 -ны № 428 -т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт”-ийн тайлангийн төсөлд
манай байгууллагаас тусгах ямар нэгэн санал
байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АЙДЫН

